## 1.ГЕГ-ЫН ХУУЛИЙН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЧИГЛЭЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

**Хүрэх үр дүн:**

1.Гаалийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг холбогдох ЗББН-ээс гаргуулан авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

**Шалгуур үзүүлэлт:**

Хэрэгжилт, гүйцэтгэлээр

**Биелэлт:**

***1.1.Гаалийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг холбогдох ЗББН-ээс гаргуулан авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.***

2023 онд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох эрх зүйн акт болон төрийн удирдах дээд байгууллагаас иргүүлсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Гаалийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагаа, гаалийн хилээр зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 167 хууль тогтоомжийг олж тогтоон жагсаалт үүсгэн хууль тогтоомжийн сан үүсгэсэн. Үүнд:

Олон улсын гэрээ 5, хууль 80, УИХ-ын тогтоолоор батлагдсан эрхийн акт 20, Засгийн газрын тогтоолоор батлагдсан эрхийн акт 62.

Эдгээрээс Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 29 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн үндсэн үүрэг, чиг үүрэгт нь хамааруулж дараах 54 эрхийн актын хэрэгжилтийг тайлагнах нэгжүүдийг тодорхойлон хүргүүлсэн. Үүнд:

| № | Зохион байгуулалтын бүтцийн нэгж | тоо | Хууль тогтоомжийн нэр |
|---|---|---|---|
| 1 | Гаалийн бүрдүүлэлтийн газар | 2 | 1.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль,<br>2.Онцгой албан татварын тухай хууль |
| 2 | Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар | 3 | 1.Зөрчлийн тухай хууль<br>2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<br>3.Татварын ерөнхий хуль |
| 3 | Татварын орлогын газар | 8 | 1.Татварын Ерөнхий хууль,<br>2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль<br>3. Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль<br>4. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль<br>5. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль<br>6. Онцгой албан татварын тухай хууль<br>7.Онцгой албан татвараас чөлөөлөх тухай хууль |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 8. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай |
| 4 | Гаалийн хяналт, шалгалтын газар | 17 | 1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль<br>2. Байгалийн ургамлын тухай<br>3. Валютын зохицуулалтын тухай<br>4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/<br>5. Органик хүнсний тухай<br>6. Хүнсний тухай хууль<br>7. Соёлын өвийг хамгаалах тухай<br>8. Тамхины хяналтын тухай /шинэчилсэн найруулга/<br>9. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай<br>10.Химийн хорт болон аюултай бодисын тухай Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай<br>11. Хог хаягдлын тухай<br>12. Хувиргасан амьд организмын тухай<br>13. Чөлөөт бүсийн тухай<br>14. Цөмийн энергийн тухай хууль<br>15. Цөмийн зэвсгээс ангид байх тухай<br>16. Эм, эмнэлгйн хэрэгслийн тухай хууль<br>17. Эрүүл мэндийн тухай хууль |
| 5 | Гаалийн зөрчилтэй тэмцэх, хэрэг бүртгэх газар | 6 | 1.Зөрчлийн тухай хууль<br>2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай<br>3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<br>4. Эрүүгийн хууль<br>5. Соёлын өвийг хамгаалах тухай хууль<br>6. Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль |
| 6 | Төрийн захиргааны удирдлагын газар | 2 | 1. Төрийн албаны тухай хууль<br>2. Хүний хувиийн мэдээллийг хамгаалах тухай хууль |
| 7 | Гаалийн хорио, цээрийн газар | 10 | 1. Тамхины хяналтын тухай /шинэчилсэн найруулга/<br>2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай<br>3. Химийн хорт болон аюултай бодисын тухай<br>4. Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай<br>5. Хувиргасан амьд организмын тухай<br>6. Хүнсний тухай хууль<br>7. Цөмийн энергийн тухай хууль<br>8. Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль<br>9. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байплын тухай хууль |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 10.Амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио, цээрийн хяналт, шалгалтын тухай хууль |
| 9 | Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс | 2 | 1.Төсвийн тухай хууль<br>2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай<br>3.Төрийн хэмнэлтийн хууль |
| 11 | Боомтын хөгжлийн хэлтэс | 1 | Монгол улсын Хилийн боомтын тухай хууль |
| 12 | Мэдээллийн технологийн төв | 2 | 1. Цахим гарын үсгийн тухай хууль<br>2. Кибер аюулгүй байдлын тухай хууль |
| 13 | Гаалийн төв лаборатори | 1 | Гаалийн тухай хууль |
| | Бүгд | 54 | |

Эдгээрээс 54 хууль тогтоомжийг ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийн нэр бүхий нэгжүүдэд хүргүүлсэн бөгөөд тэдгээр нэгжээс хэрэгжилтийн тайланг, нэгтгэн ТЗУГ, ХШҮДАГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн.

Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар 1992-2023 онд батлагдсан нийт 1547 эрхийн актын жагсаалт үүсгэж, эдгээрт хүчингүй болгосон эрхийн актууд, нэмэлт, өөрчлөлт оруулсан байдал зэрэг холбогдох хөдөлгөөнийг жил бүр хийж баяжуулан  бүртгэл хөтлөн ажиллаж байна.

***ГААЛИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР ДАРААХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАСАН БАЙНА. ҮҮНД:***

| № | Эрх зүйн актын нэр | Хуулийн холбогдох заалт | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|
| 1. | Байгалийн ургамлын тухай хууль Б-Б-1995.04.11 М-1995.06.05 | <<....Ургамлын олон наст үндэс, үндэслэг иш, булцууг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг хориглоно. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/ 4.Нэн ховор,...>> <<...н олон наст үндэс, үндэслэг иш, булцууг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг хориглоно. /Энэ хэсгийг 2010 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн/ 4.Нэн ховор, ховор ур...>> | Байгалийн ургамлын тухай хуулийн тус заалтыг үндэслэн БОАЖЯ-аас 2023 онд "Астра рүүт" ХХК, Монгол Улсын Их Сургууль, Эко петролиум ХХК, Мөнххакер ХХК-д тус тус олгосон "Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг гадаадад гаргах зөвшөөрөл"-ийг үндэслэн:<br>- Тарималжуулсан хунчир 14.35 тн;<br>- Ургамлын судалгааны дээж 1.9 кг;<br>-Таримал Дэрэвгэр жиргэрүү 20 тн-ийг гаалийн автоматжуулсан мэдээллийн систем CAIS-ын квотын програмд бүртгэн, гаалийн хяналт тавьж ажилласан. |
| 2. | Байгаль орчныг хамгаалах тухай хууль Б-1995.03.30 М-1995.06.05 | | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газраас гаргасан шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т байгалийн баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох, 4-т амьтан, ургамал, түүнчлэн байгалийн гаралтай түүхий эд экспортлох, импортлоход хил гааль, хорио цээрийн хяналтыг зохион байгуулна гэж тус тус заасан. |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td>Засгийн газраас түр хугацаагаар хориглосон байгалийн баялгийн жагсаалтыг гаалийн бүрдүүлэлтийн програмд бүртгэн хяналт тавьж ажиллаж байна.</td></tr>
<tr><td>3.</td><td>Валютын зохицуулалтын тухай хууль<br>1994.05.12<br>1994.06.01</td><td>13 дугаар зүйл. Валютыг Монгол Улсын хилээр оруулах, гаргах<br><br>1.Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг гаалийн байгууллагад бичгээр мэдүүлсэн тоо, хэмжээгээр тус улсын хилээр оруулж болно.<br><br>2. Монгол Улсад байнга болон түр оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүн валютыг дор дурдсан журмаар тус улсын хилээр гаргаж болно:<br><br>1/гадаад төлбөр, тооцооны эрх бүхий арилжааны банкнаас худалдан авсан, чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг тухайн банкны нотолгоо бичгээр;<br><br>2/гадаадаас оруулж ирсэн бол түүнийгээ нотлох гаалийн мэдүүлгээр;<br><br>3/өв залгамжлан авсан болон бусдаас бэлэглэсэн бол</td><td>Валютын зохицуулалтын тухай хуулиар Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг улсын хилээр валют гаргах, оруулах эрхийг нээж, холбогдох зохицуулалтуудыг тусгаж өгсөн. Эдгээр статус бүхий зорчигчдын улсын хилээр бэлэн мөнгө нэвтрүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ гэж заасан.<br><br>Эдгээр хуульд нийцүүлэн Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 тоот тушаалаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ыг мөрдөн ажиллаж байна.<br><br>Зорчигчийн бэлэн мөнгөний хяналтыг CAIS системийн Эрсдлийн удирдлага хэсгийн Бэлэн мөнгөний хяналтын програмын бүртгэл хэсэгт бүртгэж, хяналт тавьж ажиллаж байна.<br><br>Хүснэгт 1. 2023 онд бэлэн мөнгөний хяналтын програмд бүртгэгдсэн валютын хэмжээ:<br><br><table><tr><th>№</th><th>Валютын код</th><th>Валютын хэмжээ</th><th>Давтамж</th></tr><tr><td>1</td><td>AUD</td><td>81,500.0</td><td>8</td></tr><tr><td>2</td><td>CNY</td><td>10,618,820.0</td><td>331</td></tr><tr><td>3</td><td>EUR</td><td>362,555.0</td><td>124</td></tr><tr><td>4</td><td>GBP</td><td>9,000.0</td><td>2</td></tr></table></td></tr>
</table>

<table>
<tr><td></td><td></td><td>үүнийгээ тус улсын нотариатын байгууллагын нотолгоо бичгээр;<br><br>4/Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар.<br><br>3.Монгол Улсын иргэн чөлөөтэй хөрвөдөг гадаад валютыг хуулиар хязгаар тогтоогоогүй бол гаальд мэдүүлсэн тоо хэмжээгээр тус улсын хилээр гадаадад гаргаж болно.</td><td><table>
<tr><td>5</td><td>HKD</td><td>702,300.0</td><td>4</td></tr>
<tr><td>6</td><td>JPY</td><td>188,970,810.0</td><td>49</td></tr>
<tr><td>7</td><td>KPW</td><td>58,900,000.0</td><td>4</td></tr>
<tr><td>8</td><td>KRW</td><td>3,795,828,674.0</td><td>137</td></tr>
<tr><td>9</td><td>KZT</td><td>480,000</td><td>2</td></tr>
<tr><td>10</td><td>MNT</td><td>127,459,600.0</td><td>222</td></tr>
<tr><td>11</td><td>RUB</td><td>789,572,381.0</td><td>10225</td></tr>
<tr><td>12</td><td>THB</td><td>97,277,453.4</td><td>34</td></tr>
<tr><td>13</td><td>TRY</td><td>140,900.0</td><td>3</td></tr>
<tr><td>14</td><td>TWD</td><td>98,900.0</td><td>8</td></tr>
<tr><td>15</td><td>USD</td><td>10,117,235.0</td><td>1191</td></tr>
</table></td></tr>
<tr><td>4</td><td>Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль<br>2013.05.13<br>2013.05.31</td><td>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.</td><td>Мөнгө угаах болон тероризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт зорчигч 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлэх бол энэ тухай гаалийн мэдүүлэгт үнэн зөв мэдүүлнэ гэж заасан.<br><br>Эдгээр хуульд нийцүүлэн Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 тоот тушаалаар батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-ыг мөрдөн ажиллаж байна.</td></tr>
<tr><td rowspan="2">5</td><td rowspan="2">Соёлын өвийг хамгаалах тухай хууль<br>Б-2014.05.15<br>М-2014.07.01</td><td><<... Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг <b>улсын хилээр</b> нэвтрүүлэх ийг хориглоно. 6 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг ... >></td><td rowspan="2">Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн заалтыг үндэслэн Соёлын яамнаас 2023 онд Археологийн хүрээлэн, Палентлогийн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төв, Монголын үндэсний музэй, Монгол Улсын Их Сургуулиудад давхардсан тоогоор олгосон лицензийн дагуу археологийн судалгааны дээж, мал амьтны яс, эд өлгийн зүйл, үлэг гүрвэлийн ясны хэлтэрхий, чулуужсан өндөгний дээж гэх мэт 2398 барааны 23 квотыг гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS системын квотын програмд бүртгэн хяналт тавьж ажилласан.</td></tr>
<tr><td><<... Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол,</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг **улсын хилээр** нэвтрүүлэх ийг хориглоно. 6 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх талаар аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг ...>> | |
| 6 | Тамхины хяналтын тухай хууль | <...аар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/ 8.2.Тамхины бүх төрлийн зар сурталчилгааны материалыг улсын **хилээр нэвтрүүлэх**ийг хориглоно. /Энэ хэсэгт 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ 8.3.Тамхи...>> | Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө аж ахуйн, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар олгоно.<br>Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр олгоно. Сонгон шалгаруулах журмыг Засгийн газар батлахаар заасан.<br>Дээрх хуулийн дагуу гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS системын “Импортын лицензи” талбарт импортоор оруулах тамхи, тамхин бүтээгдэхүүний БТКУС-ийн ангиллын код тус бүрээр мэдээлэл оруулж, холбогдох тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд тухайн барааг улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болгон хяналт тавьж ажиллаж байна.<br>Зорчигчийн хувийн хэрэглээний тамхи, тамхин бүтээгдэхүүний хувьд Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/223 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйлийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам”-аар гаалийн болон бусад албан татваргүйгээр гаалийн хилээр нэвтрүүлэх зорчигчийн бараа, тоо хэмжээг тогтоосон.<br>Журмын 2.3.1-д Архины зүйлс 2 литр, дарс 2 литр, шар айраг 3 литр, янжуур 200 ширхэг, сигар, навчин тамхи 50 ширхэг, задгай тамхи 250 граммаас илүүгүй, 2.4-д Энэ журмын 2.3.1-д заасан бараа 18 насанд |
| | | <<...аар сарын 24-ний өдрийн хуулиар нэмсэн/ 8.2.Тамхины бүх төрлийн зар сурталчилгааны материалыг улсын **хилээр нэвтрүүлэх ийг** хориглоно. /Энэ хэсэгт 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан/ 8.3.Тамхи...>> | |
| | | <<...Г ТАМХИНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ХЭРЭГЛЭЭ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ 6 дугаар зүйл. Тамхи импортлох, **экспорт лох**, үйлдвэрлэх, худалдах, хэрэглэхэд тавих шаардлага /Энэ зүйлийн гарчигт 2015 оны 1 дүгээр сарын 2...>> | |

| | | | |
|---|---|---|---|
| | | | хүрээгүй болон хилээр гараад 24 цагийн дотор буцаж орж байгаа зорчигчид хамаарахгүй гэж заасныг үндэслэн хяналт тавьж ажиллаж байна.<br>Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд оруулах саналыг ГЕГ-ын Хуулийн хэлтэст хүргүүлсэн. |
| 7 | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль Б-2013.01.31 М-2013.03.04 | <<...й хэрэгслийн эргэлт" гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, **экспортлох,** худалдах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааг; 4.1.5."тэсэрч дэлбэрэх бод...>> | Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 8.10-т заасны дагуу үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, экспортлоход УУХҮЯ-аас олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн дээрх төрлийн бараанд гаалийн бүрдүүлэлт хийж, улсын хилээр нэвтрүүлж байна.<br>Гаалийн байгуулага тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд гаалийн байгууллагын автоматжуулсан CAIS системын "Импортын лицензи" талбарт импортоор оруулах тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн БТКУС-ийн ангиллын код тус бүрээр мэдээлэл оруулж, холбогдох тусгай зөвшөөрөлгүй тохиолдолд улсын хилээр нэвтрүүлэх боломжгүй болгон, хяналт тавьж ажиллаж байна.<br>Мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд 2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хилээр нэвтрүүлсэн тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тайлан мэдээг гаргаж 2023.04.21-ний өдрийн 02/1414 дугаартай албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн. |
| 8 | Химийн хорт болон аюултай бодисын тухай Б-2006.05.25 М-2006.05.25 | <<... үндэслэл 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь химийн хорт болон аюултай бодисыг **экспортлох**, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон | Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/40 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам"-ын 3.1.4-д заасны дагуу Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд Байгаль орчин, аялал |

| | | | |
|---|---|---|---|
| | | үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэр...>> | жуулчлалын яамнаас олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийж байна.<br>“Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-д өөрчлөлт оруулсан БОАЖ-ын Сайд, Гадаад харилцааны сайдын 2020 оны А/60, А/12 дугаартай хамтарсан тушаалыг хэрэгжүүлэх чиглэлийг гаалийн газар, хороодын дарга нарт хүргүүлсэн.<br>Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн тушаал, албан бичиг, Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөлд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэрийг дотоод сүлжээний CERP системд байршуулж, гаалийн газар, хороодод мэдээлсэн.<br>CAIS-ын “Барааны код” хэсэгт БТКУС-ын ангиллын код тус бүрээр оруулсан Тарифын бус хязгаарлалттай бараа, хориглосон барааны дэлгэрэнгүй тайлбарт нэмэлт өөрчлөлтийн мэдээллийг тухай бүр оруулж байна.<br>АХБ-ны санхүүжилтээр “Аюултай химийн бодисын удирдлагыг сайжруулах” төслийг БОАЖЯ, ГЕГ-аас Интерактив ХХК-тай хамтран гүйцэтгэж байна. Энэхүү төсөл нь:<br>-Монгол улсад хэрэглэгдэж буй бүх химийн хортой болон хоргүй бодисын нэгдсэн суурь бүртгэлийг хийх;<br>-Монгол улсын хилээр нэвтэрч буй бүх химийн хортой болон хоргүй бодисын шилжилт хөдөлгөөнийг тухайн бодис устгалд орох хүртэл хугацаанд бүртгэлээр хянаж, хяналтыг сайжруулах;<br>-химийн бодисын бүртгэл дээр үндэслэн аж ахуйн нэгжүүдийн химийн бодис дээр авч буй тусгай зөвшөөрлийг бүртгэх, |

| | | | |
|---|---|---|---|
| | | | -бүртгэсэн тусгай зөвшөөрлийг хянах, өөрчлөлтийг бүртгэлжүүлэх үндсэн зорилготой Химийн бодисын удирдлагыг сайжруулах цогц систем юм. Төсөл хэрэгжсэнээр:<br>-Химийн бодисын бүртгэлийн системийг шинээр хөгжүүлэх;<br>-Мобайл аппликейшныг шинээр хөгжүүлэх;<br>-Химийн бодисын бүртгэлийн мэдээллийн санг бий болгох;<br>-Химийн бодисын бүртгэлийн мэдээллийн сангийн кодчлолыг сайжруулах;<br>-Аж ахуйн нэгжүүдийн химийн бодисын тусгай зөвшөөрлийг бүртгэлжүүлэх, хяналт тавих, түүний мэдээллийн урсгалыг сайжруулах;<br>-Бусад төрийн байгууллагуудын програм хангамжтай холбогдож ажиллах, мэдээлэл солилцох;<br>-Мэдээллийн урсгалыг сайжруулах, уялдаа холбоог сайжруулна.<br>Прогаммын хөгжүүлэлтийг Олон нийтэд зориулагдсан вэб портал, ААН-үүдэд зориулсан вэб портал, Мобайл хөгжүүлэлт Мэргэжилтэн ажиллах удирдлагын систем гэсэн 4 чиглэлээр гүйцэтгэж, захиалагч болон зөвлөхүүдийн саналын дагуу шаардлагатай сайжруулалтыг хийн, бүрэн ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар програмын ажил дууссан бөгөөд интеграцийн холболт, туршилтын ажил үргэлжлэн явагдаж байна.<br>Мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/152 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан 2009 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн 334/104 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах” үүрэг бүхий ажлын хэсэгт |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар тус ажлын хэсгийн 4 удаагийн хуралд оролцож, холбогдох саналыг хүргүүлсэн.<br><br>Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, санал дүгнэлт гаргах” чиг үүрэг бүхий Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн шинжээчдийн багийн бүрэлдэхүүний 2023 оны 4 удаагийн хуралд оролцсон.<br><br>Тарифын бус хязгаарлалттай бараа, хориглосон барааны дэлгэрэнгүй тайлбарыг 2020 оноос эхлэн БТКУС-ын ангиллын 1141 код тус бүрээр CAIS-ын “Барааны код” хэсэгт оруулж, гаалийн газар, хороодын ГУБ, ГУАБ нарт шаардлагатай мэдээллүүдийг хүргэн, тарифын бус хязгаарлалттай бараа, хориглосон бараанд тавих хяналтын үр дүнг сайжруулсан.<br><br>CAIS-ын “Барааны код” хэсэгт 2023 онд холбогдох нэмэлтийг оруулж, хяналт тавьж ажиллаж байна. |
| 9 | Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай<br>Б-2002.11.17<br>М-2002.11.17 | <<...йн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, импортлоход **гаалийн хилээр** нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг хүчингүй болгох; 5.1.5.Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал,...>><br><<... газарт уламжлах; 5.1.4.Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг **экспортлох,** импортлоход | Харьяа гаалийн байгууллагын эрх хэмжээг тодорхой бараагаар хязгаарлах тухай Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/246 дугаартай тушаалаар:<br><br>1.Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 1 дүгээр хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйл болон Идлэг шонхорыг Буянт-ухаа боомтоор;<br><br>2.Зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн 2 дугаар хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг Буянт-Ухаа, Замын-үүд, Алтанбулаг, Сүхбаатар боомтоор тус тус нэвтрүүлж байхаар |

| | | | |
|---|---|---|---|
| | | гаалийн хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, уг зөвшөөрлийг хүчингүй болгох; 5.1.5.Ко...>><br><<...рчин, үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, **гааль**, мэргэжлийн хяналт хариуцсан төрийн захиргааны байгууллага, байгаль орчны чиглэлийн төрийн бус байг...>> | тогтоосныг үндэслэн тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>2023 онд БОАЖЯ-аас олгосон Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, зүйлийг гадаадад гаргах зөвшөөрөл, CITES-ын зөвшөөрлийг тус тус үндэслэн CAIS-ын Квотын програмд мэдээллийг бүртгэж, хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:<br>- 97 зөвшөөрлөөр 342 идлэг шонхор;<br>- 11 зөвшөөрлөөр 124.5 тн Бугын ясан эвэр;<br>- 66 зөвшөөрлөөр 69 ширхэг Алтайн болон Говийн тэхийн арьс;<br>- 20 зөвшөөрлөөр 20 ширхэг Халиун бугын арьс;<br>- 64 зөвшөөрлөөр 69 ширхэг /толгой/ Алтайн болон Говийн тэхийн эвэр дагз;<br>- 3 зөөвшөөрлөөр 3 ширхэг /толгой/ Халиун бугын эвэр дагз;<br>- 29 зөвшөөрлөөр 29 ширхэг/ толгой/ Цагаан зээрийн эвэр дагз;<br>- 20 зөвшөөрлөөр 20 ширхэг Цагаан зээрийн арьс;<br>- 172 зөвшөөрлөөр 7658 тн Хуш модны боловсруулсан самрын идээ гадаадад гаргах зөвшөөрлийг тус тус бүртгэсэн байна. |
| 10 | Хог хаягдлын тухай хууль 2017.05.17 | <<...г бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, **экспортлох** болон хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицу...>> | Хог хаягдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх заалт болон Засгийн газрын 2019 оны "Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалтад нэмэлт оруулах тухай" 199 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд гаалийн автоматжуулсан CAIS системын Гаалийн бүрдүүлэлт-тарифын бус хязгаарлалт-БТКУС-ийн тайлбар дүгнэлт талбарт аюултай хог хаягдлын БТКУС-ийн ангиллын код, Засгийн газрын 2019 оны 199 дүгээр тогтоолоор хориглосон барааны код тус бүрээр анхааруулга оруулсан.<br>CAIS системд нэвтэрч байгаа гаалийн албан хаагч нар, CEPS системээр хандаж буй мэдүүлэгч нар системд дээрх барааны БТКУС- |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ийн кодыг оруулахад “хориглосон” гэсэн анхааруулга гарах бөгөөд гаалийн бүрдүүлэлт, хяналт шалгалтын үр дүн, хэрэгжилтэд чухал ач холбогдол өгч байна. |
| 11 | Хувиргасан амьд организмын тухай хууль Б-2007.06.28 М-2007.06.28 | <<... 6 дугаар зүйл.Хувиргасан амьд организмыг улсын хилээр нэвтрүүлэх 6.1.Хувиргасан амьд организмыг **экспортлох,** импортлох, дамжин өнгөрүүлэх зөвшөөрлийг Үндэсний хорооны дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асу...>> | Хувиргасан амьд организмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийн дагуу хилээр нэвтрүүлэх хувиргасан амьд организмд гаалийн байгууллага хяналт тавин ажиллаж байна. |
| 12 | Хүнсний тухай хууль Б-2012.03.01 М-2013.03.01 | <<....2.хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд тавих төрийн хяналт; 13.1.3.хүнс экспортлох, импортлоход тавих гаалийн болон хорио цээрийн хяналт; 13.1.4.стратегийн хүнс экспортлох, импортлох тохиолдолд энэ хуулийн 6.8...>> | Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжөөр Монгол Улсын 2023 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, too хэмжээг тогтоосон. Үүнд:<br>**Импорт:**<br>- Үрийн улаанбуудай-10000 тн;<br>- Хүнсний улаанбуудай 50000 тн;<br>- Улаанбуудайн гурилын импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байх;<br>- Савласан цэвэр ус 3400 тн;<br>**Экспорт:**<br>- Улаанбуудайн гурил 20000 тн;<br>- Савласан цэвэр усны экспортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй.<br>ХХААХҮЯ-аас ирүүлсэн зөвшөөрөл, мэдэгдлийн дагуу гаалийн байгууллага стратегийн хүнсний квотыг гаалийн байгууллагын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | автоматжуулсан CAIS системын квотын програмд оруулж, хяналт тавьж ажиллаж байна.<br>Стратегийн хүнсний импортын мэдээ, тайланг ХХААХҮЯ-ны холбогдох нэгжид хагас жил, бүтэн жилээр хүргүүлж ажиллаж байна. |
| 13 | Цөмийн энергийн тухай Б-2009.07.16 М-2009.08.15 | <<...рьяалах нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгаа зохион байгуулах. 14 дүгээр зүйл. Хил хамгаалах болон **гаалийн байгууллага**, түүний албан тушаалтны бүрэн эрх 14.1.Хил хамгаалах болон ...>><br><<...өөрөмжийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хяналт тавих; 111.1.7.улсын **хилээр нэвтрүүлэх** цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгу...>> | 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хооронд:<br>- 38 аж ахуйн нэгжийн хилээр нэвтрүүлсэн 164874.621 ам долларын статистик үнийн дүн бүхий 32,32 кг ангилалтын тоо хэмжээ бүхий цацраг идэвхт изотоп (Cs-137, Cd-109, Am-241, Am-241/Be, Ge-68, Mo-99/Tc-99m, I-131),<br>- 233 аж ахуйн нэгжийн хилээр нэвтрүүлсэн 13.038.369,99 ам долларын статистик үнийн дүн бүхий 240 ширхэг рентген аппарат, 14 ширхэг рентген хоолой, аюулгүй байдлыг хангуулан цөмийн болон цацрагийн хяналт шалгалтыг хийсэн. |
| 14. | Цөмийн зэвсгээс ангид байх тухай 2000.02.02 | <<...цөмийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон бусад эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр **дамжуулан өнгөрүүлэх** ийг хориглоно. 5 дугаар зүйл. Цөмийн эрчим хүч, технологи ашиглах 5.1. Цөмийн эрчим хүч, технологийг...>> | 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар гаалийн хилээр цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэй бараа (цөмийн эрчим хүч, технологи) нэвтрээгүй байна. |
| 15. | Чөлөөт бүсийн тухай хууль | <<...уульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.“чөлөөт бүс” гэж | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7, $268^{1}$ дугаар зүйлийн $268^{1}$.1.1, $269^{1}$ дүгээр зүйлийн $269^{1}$..1.1, $270^{1}$ дугаар |

| | | | |
|---|---|---|---|
| | | **гаалийн татвар** болон бусад татварын хувьд ...>><br><br><<...дэх үйл ажиллагааны тусгай дэглэм” гэж хөрөнгө оруулалтыг татах, шинэ технологийг нэвтрүүлэх, **экспорт ыг** дэмжих, аялал жуулчлал, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхэлж байгаа а...>><br><br><<...тан буулгах, түүний байршил, удирдлагын эрх хэмжээ, хяналтын тогтолцоо, чөлөөт бүсэд мөрдөх татвар, **гааль**, шалган нэвтрүүлэх, хуулийн этгээдийн болон иргэний бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн тусгай дэглэмийн э...>> | зүйлийн $270^1$.1.4, $271^1$ дүгээр зүйлийн $271^1$.1.1, $271^1$.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ыг баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 4571 дугаарт бүртгүүлэн нийтээр дагаж, мөрдөж байгаа болно.<br><br>Замын-Үүд, Алтанулаг, Цагааннуур чөлөөт бүсүүдэд 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 8610 удаагийн тээврийн хэрэгслээр 30531 зорчигч нэвтэрч, 1,299,739,270 төгрөгийн үнийн дүнтэй, 28234 нэр төрлийн 52963 ширхэг барааг гаалийн болон бусад татваргүй үнээр худалдан авсан байна.<br><br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Л3936-МОН: “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн Замын-Үүд чөлөөт бүсийн барилгын ажлын нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний Сонголт дизайн ХХК-иас 2023.04.28-ны өдөр зохион байгуулсан хилийн хяналтын байгууллагуудын хамтарсан хуралд оролцсон.<br><br>Мөн тус төслийн хүрээнд Замын-Үүд чөлөөт бүсийн барилгын ажлын нарийвчилсан инженерийн зураг төслүүдтэй танилцаж, гүний гарцын шалган нэвтрүүлэх нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилгын зураг 3, ерөнхий төлөвлөгөөнд тусгуулах саналаа 2023.05.30-ны өдрийн 02-1/2045 дугаартай албан бичгээр хүргүүлэн хамтарч ажиллаж байна. |
| 16. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль 2010.05.27 | <<...ҮЛЭГ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ 14 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын **хилээр нэвтрүүлэх** 14.1.Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын ...>> | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомт тогтоох тухай” 73 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийг Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд боомтоор нэвтрүүлэхээр тогтоож, 2021 оны “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 342 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтын жагсаалтанд Гашуунсухайт, Ханги боомтуудыг нэмсэнтэй холбогдуулан тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Тарифын бус хязгаарлалттай барааны хяналтыг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас ирүүлсэн мэдээллийг Захиргаа дотоод ажлын систем CERP-д тухай бүр байршуулсан. Үүнд:<br>- Барагшунд гаалийн бүрдүүлэлт хийх тухай-1;<br>- Стандартын бус эмийн сэрэмжлүүлэг-2 ;<br>- Хуурамч эмийн сэрэмжлүүлэг-3.<br>- Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд олгосон импорт, экспортын 2023 оны 2 дугаар улирлын импорт, экспортын лиценз;<br>- 2023 оны 2 дугаар улиралд олгосон Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмийн импортын лицензийн мэдээ;<br>- Соёлын яам, Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын гарын үсгийн баталгаа;<br>- 2023 оны 3 дугаар улиралд олгосон лицензийн мэдээлэл.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн нэг удаагийн лицензийг “И-Монголиа”-аар дамжуулан цахимаар олгож байгаа тухай ЭЭХХЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/2095 дугаартай албан бичгийг үндэслэн лицензийг цахимаар шалгаж байна.<br>Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн /БТКУС/ 30 бүлэгт заасан 162.5 сая ам долларын статистик үнийн дүнтэй Эм зүйн бүтээгдэхүүнийг 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 331 аж ахуйн нэгж 4231 импортын гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийлгэж улсын хилээр оруулсан байна. |
| 17. | Эрүүл мэндийн тухай хууль 2011.05.05 | <<...о: 19.3.1.эмнэлгийн тусламж, үйлчилгээ эрхлэх; 19.3.2.эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, | Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.2-д заасан "эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх" заалт болон Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр |

| | | | |
|---|---|---|---|
| | | **экспортлох,** хանган нийлүүлэх; 19.3.3.мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, эмийн бодис, угтвар бодис болон эм...>> | нэвтрүүлэх боомтыг Засгийн газрын тогтооно" гэж заасны дагуу ЗГ-ын 73 дугаар тогтоолд дурдсан хилийн боомтуудаар нэвтрүүлж буй эм, эмнэлгийн хэрэгсэлд хяналт тавьж, ажиллаж байна. |
| ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ | | | |
| | Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай | | ХХААХҮЯ-аас 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/773 дугаартай албан бичгийн хавсралтаар Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн “Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” 20 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэл ирүүлсэн. Дээрх тогтоолын дагуу 2023 оны 11 дүгээр сарын байдлаар:<br>- 44 иргэн, аж ахуйн нэгж 300 үржлийн адуу импортлохоос 31 иргэн, аж ахуйн нэгж 231 үржлийн адуу;<br>- 18 иргэн, аж ахуйн нэгжид 8100 толгой үхэр импортлох тоо хэмжээ тогтоосноос 5 иргэн, аж ахуйн нэгж 425 толгойг;<br>- 5 иргэн, аж ахуйн нэгжид 1000 мл бухын үр импортлох тоо хэмжээ тогтоосноос 3 иргэн, аж ахуйн нэгж 245 мл;<br>- 5 иргэн, аж ахуйн нэгжид 9,410.0 мян.ширхэг үржлийн өндөг импортлох тоо хэмжээ тогтоосноос 3 иргэн, аж ахуйн нэгж 3,190.04 мян.ширхэг;<br>- 5 иргэн, аж ахуйн нэгжид 6500 мл хонь, ямааны хөврөл үр импортлох тоо хэмжээ тогтоосноос 2 иргэн, аж ахуйн нэгж 369.45 мл;<br>- 3 иргэн, аж ахуйн нэгжид 330000 толгой үржлийн дэгдээхий импортлох тоо хэмжээ тогтоосноос 1 иргэн, аж ахуйн нэгж 8890 толгойг;<br>- 7 иргэн, аж ахуйн нэгжид 24,300 мян.ширхэг үржлийн зөгий, импортлох тоо хэмжээ тогтоосноос 4 иргэн, аж ахуйн нэгж 1,467.03 мян.ширхэгийг тус тус импортоор оруулсан байна. |

***ГААЛИЙН ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААРХ ДАРААХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАСАН БАЙНА. ҮҮНД:***

| № | Эрх зүйн актын нэр | Огноо | Мөрдөж эхэлсэн огноо | Зөрчлийн мэдээлэл | Дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Зөрчлийн тухай хууль | 2015 12.04 | 2016 09.01 | 2023 оны байдлаар Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдсэн зөрчлийн зүйлчлэлийн байдал:<br>• Гаалийн тухай хууль зөрчих -***1573*** удаа<br>• Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль зөрчих -***60*** удаа<br>• Хүнсний тухай хууль зөрчих -***4*** удаа<br>• Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих -***13*** удаа<br>• Тамхины хяналтын тухай хууль зөрчих -***4*** удаа<br>• Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль зөрчих -***41*** удаа<br>• Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих -***13*** удаа<br>• Хууль бусаар галт зэвсэг эзэмших -***33*** удаа<br>• Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зөрчих -**2** удаа | ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалалийн дагуу “гаалийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу албан хаагчдаас хялбаршуулсан журмаар ***1598*** удаагийн гаалийн зөрчлийг шийдвэрлэж, гаалийн болон бусад татвар ***9061.2*** сая төгрөгийг нөхөн төлүүлж, ***4,530.6*** сая төгрөгийн торгуулийг төлүүлжээ. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | • Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллгаанд нь саад учруулах -***14*** удаа | |
| 2 | Зөрчил шалган тухай хууль | 2017 05.19 | 2017 07.01 | 2023 оны байдлаар Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж шийдвэрлэгдсэн зөрчлийн зүйлчлэлийн байдал:<br>• Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль зөрчих -***3*** удаа<br>• Гаалийн тухай хууль зөрчих -1***9*** удаа<br>• Хүнсний тухай хууль зөрчих -1 удаа<br>• Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль зөрчих -1 удаа<br>• Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллгаанд нь саад учруулах ***-1 удаа*** | ЗШШТХ-ийн 1.8 дугаар зүйлд заасан Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалалийн дагуу “гаалийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу албан хаагчдаас зөрчлийн хэрг бүртгэлт явуулж ***25*** удаагийн гаалийн зөрчлийг шийдвэрлэж, гаалийн болон бусад татвар ***171***,6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, ***90***,***2*** сая төгрөгийн торгуулийг төлүүлжээ. |
| 3 | Эрүүгийн хууль | 2015 12.03 | 2014 07.01 | 2023 оны байдлаар Эрүүгийн хуулийн холбогдох заалтуудаар хойшлуулшгүй ажиллагаа явуулж хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн байдал:<br>• 18.5 дугаар зүйл. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх -***21*** удаа<br>• 20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах -***13*** удаа | 2023 оны байдлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.8-д заасныг баримтлан ***34*** удаа хойшлуулшгүй ажиллагаа явуулж,<br>хууль, хяналтын байгууллагад зөрчилд холбогдсон бараа болох 5***50***,***2*** сая төгрөгийн үнийн дүн бүхий эд зүйлийг шилжүүлэн ажиллсан байна. |

### ГААЛИЙН ТАРИФ, ТАТВАРЫН ТАЛААРХ ДАРААХ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ АЖИЛЛАСАН БАЙНА. ҮҮНД:

| № | Эрх зүйн актын нэр | Батлагдсан огноо | Хуулийн заалт | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 6 |
| 1 | Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай | 1996.03.29 | 3 дугаар зүйл. Мод, зүсмэл материалд дор дурдсан хэмжээгээр экспортын гаалийн татвар ногдуулсугай: | Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуулийн 3 дугаар зүйлийн дагуу 32174 ам.долларын үнийн дүн бүхий Мод, зүсмэл материалд 19 сая төгрөгийн гаалийн албан татвар ногдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн. |
| 2 | Татварын ерөнхий хууль | 2019.03.22 | | Татварын ерөнхий хуульд заасан татварын төрлүүдээс Гаалийн байгууллага нь 2023 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 4720,0 тэрбум төгрөг төвлөрүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг 91.5 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>- Гаалийн албан татвар 1293.2 тэрбум төгрөг,<br>- Нэмэгдсэн өртгийн албан татвар 2782.1 тэрбум,<br>- Архи, дарсны онцгой албан татвар 33.2 тэрбум төгрөг,<br>- Тамхины онцгой албан татвар 129.7 тэрбум төгрөг,<br>- Шар айргийн онцгой албан татвар 7.9 тэрбум төгрөг,<br>- Суудлын автомашины онцгой албан татвар 283.7 тэрбум төгрөг,<br>- Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 12.3 тэрбум төгрөг,<br>- Автобензин, дизелийн түлшний албан татвар 19.1 тэрбум төгрөг,<br>- Экспортын татварын орлого 44,8 сая төгрөг байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль | | | Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд импортын барааны ердийн, нэн тааламжтай, хөнгөлөлттэй тарифаар гаалийн татвар ногдуулж 2023 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 1293.2 тэрбум төгрөгийн Гаалийн албан татвар улсын төсөвт төвлөрүүлсэн байна. |
| 4 | Онцгой албан татварын тухай хууль | 2006.06.29 | | Гаалийн байгууллага 2023 онд Онцгой албан татварын тухай хуулийн хүрээнд дараах төрлийн ОАТ-ыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнд:<br>- Архи, дарсны онцгой албан татвар 33.2 тэрбум төгрөг,<br>- Тамхины онцгой албан татвар 129.7 тэрбум төгрөг,<br>- Шар айргийн онцгой албан татвар 7.9 тэрбум төгрөг,<br>- Суудлын автомашины онцгой албан татвар 283.7 тэрбум төгрөг,<br>- Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар 12.3 тэрбум төгрөг |
| 5 | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль | | | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд гаалийн байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 2782.1 тэрбум төгрөгийн НӨАТ улсын төсөвт төвлөрүүлсэн. |

***ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ***

| **Татвараас чөлөөлөх үндэслэл, хуулийн заалт** | **Татвараас чөлөөлөгдөх бараа** | **Үнийн дүн USD** | **Үнийн дүн MNT** | **Чөлөөлсөн татвар /гааль/** | **Чөлөөлсөн татвар /онцгой/** | **Чөлөөлсөн татвар /НӨАТ/** | **Нийт чөлөөлсөн татвар** |
|---|---|---|---|---|---|---|---|
| "Гаалийн тариф, гаалийн татварын тухай" | Гадаад улсын Засгийн газар, олон улсын | 41,856,792.97 | 144,917,636,177.22 | 7,228,303,326.00 | 44,154,500.00 | 15,254,534,410.00 | 22,526,992,236.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хуулийн 38.1.2 дахь заалт, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.3 дахь заалт, | байгууллагаас буцалтгүй болон хүмүүнлэгийн тусламж | | | | | | |
| “Гаалийн тариф, гаалийн татварын тухай” хуулийн 38.1.2 дахь заалт, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулийн 13.1.3 дахь заалт, МУЗГ- АНУ ЗГ хооронд 2004 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан УБ хот дахь Олон улсын сургуулийн тухай хэлэлцээр, 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн УБ хот дахь ОУ-ын сургуулийн тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль | Улаанбаатар хот дахь Олон улсын сургуулийн импортлож байгаа гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх бараа | 118,228.77 | 407,181,112.49 | 6,959,440.00 | - | 41,414,054.00 | 48,373,494.00 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10. | Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль | 2002.11.28 | 2002.11.28 | 25.1. Импортын гэрчилгээг экспортлогч улсын мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн эрх бүхий байгууллагаас олгосон экспортын гэрчилгээ, гаалийн байгууллагаас олгосон импортын мэдэгдэл, шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагч олгоно.<br>25.2.Экспортын гэрчилгээг хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 | 5.1.2.гадаад улс, олон улсын байгууллагатай мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн талаар хамтран ажиллах тухай гэрээ, хэлэлцээр байгуулах;<br>БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн экспортлохоор шинээр бүртгүүлэх хүсэлт гаргасан 24 аж ахуйн нэгжийн холбогдох материалыг хянаж, 14 аж ахуйн нэгжийн материалыг баталгаажуулан холбогдох байгууллагад уламжилсан.<br>БНХАУ-ын ГЕГ-аас МУ-аас мах, махан бүтээгдэхүүн экспортлох эрх бүхий 5 үйлдвэрт 2023 оны 02 дугаар сарын 16-наас 03 дугаар ын 06-ны өдрүүдэд цахим хяналт шалгалтыг хийсэн.<br>Монгол Улс болон БНХАУ-ын гаалийн байгууллага хоорондын “Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсад угаасан ноос, ноолуур экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн, шаардлагын тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын протокол, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан тусгайлан эрх олгосон мэргэжлийн байгууллага олгоно.<br>7.1.3.амьтан, ургамал, хүнснийхээс бусад түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлохын өмнө эрсдэлийн задлан шинжилгээ хийж импортын мэдэгдэл олгох; | БНХАУ-ын ГЕГ болон МУ-ын Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хооронд 2019 онд байгуулсан “Нядалгааны зориулалттай хонь, ямаа экспортлох үеийн хяналт шалгалт, хорио цээр, мал эмнэлэг эрүүл мэндийн тухай протокол”-ыг Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гаалийн ерөнхий газар хоорондын протоколыг тус тус эцэслэн тохиролцсон.<br>“Монгол Улсаас БНХАУ-д Байгалийн хадлан өвс экспортлох ургамлын эрүүл ахуйн шаардлагын тухай МУ-ыг ГЕГ, БНХАУ-ын ГЕГ хоорондын протокол-ыг байгуулан, экспортын ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, мал эмнэлгийн аруйн цэврийн гэрчилгээг тохиролцон экспортыг эхлүүлэхэд бэлэн болсон.<br>Мөн МУ-аас БНХАУ-д тэжээлийн зориулалттай улаанбуудайг БНХАУ-д экспортлох үеийн хорио цээрийн нөхцөл шаардлагыг тохиролцохоор холбогдох мэдээллийг солилцон ажиллаж байна. Хуулийн хэрэгжилт 100%,<br>7.1.3.”амьтан, ургамал, хүнснийхээс бусад түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлохын өмнө эрсдэлийн задлан шинжилгээ хийж импортын мэдэгдэл олгох”заалтын хүрээнд БНЭУ, БНХАУ, Япон Улсаан импортлох үхрийн мах, /вагюү/ тахианы мах, гахайн мах, загас, далайн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрүүдэд хянан магадлагаа хийсэн.<br>Хүнсний Аюулгүй Байдлын Үндэсний Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 20-ны 01 дугаартай “Улаанбуудайн гурилын импортод тоо хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байх” зөвлөмжийн дагуу ОХУ- |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | аас улаанбуудайн гурил импортлох аж ахуй нэгжүүдийн хүсэлтийг дагуу ОХУ-ын “Томские мельницы”, ООО По “Топчихинский Мелькомбинат” ООО “Вирт-М”, ООО “Зернопродукт”, СКП “Знаменский”, ООО “Мельник”, “А.В.Блинов”, ИП “Чурбанов Роман Владимирович” үйлдвэрүүдэд хянан магадлагаа хийж гүйцэтгэсэн. Хуулийн хэрэгжилт 99.9%,<br><br>12.1.1. амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтээ энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэж, зохих мэдэгдэл авсан байх; Амьтан, ургамлын дамжуулан тээвэрлэх мэдэгдэл 74 аж ахуй нэгжид олгосон байна. Хуулийн хэрэгжилт 99,9%,<br><br>25.2.”Экспортын гэрчилгээг хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан тусгайлан эрх олгосон мэргэжлийн байгууллага олгоно” заалтын дагуу мал, амьтан ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд 9812 экспортын гэрчилгээ олгож хуулийн хэрэгжилт 99.6%. Үүнийг дунджаар нь авч үзвэл 99,5%-ийн хэрэгжилттэй байна. |

| д/д | Эрх зүйн актын нэр | Батлагдсан огноо | Мөрдөж эхэлсэн огноо | Хуулийн холбогдох заалт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо | 2023.01.11 | 2023.01.11 | Малын генетик нөөцийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь | Малын генетик нөөцийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” 20 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэмжээг тогтоох тухай” | | | хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Импортлох мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг тогтоох тухай” 20 дугаар тогтоолын хэрэгжилт | дугаар тогтоолын хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд Франц, Польш, ОХУ-ааас үржлийн адуу 236 толгой, үржлийн үхэр 410 толгой, үржлийн зөгий 1467 бүл тус тус импортлогдоход гаалийн хорио цээрийн хяналт хийгдсэн байна. |

***ХИЛИЙН БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭРХ ДАРААХ ХУУЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА. ҮҮНД:***

| № | Эрх зүйн актын нэр | Батлагдсан огноо | Мөрдөж эхэлсэн огноо | Хуулийн холбогдох заалт | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол улсын Хилийн тухай хууль | 2016.12.28 | 2017.02.01 | 29.1 Хилийн боомтыг хөгжүүлэх бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Боомтын сэргэлтийн Үндэсний хороо ажиллана. | Хилийн боомтыг хөгжүүлэх бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Боомтын сэргэлтийн Үндэсний хороо 2022 оноос ажиллаж эхэлсэн.<br>Боомтын хөгжлийн хэлтэс Боомтын сэргэлтийн Үндэсний хороог хилийн боомтын тухай шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна.<br>2023 оны 01 сарын 18-ны өдрийн 01/191 албан бичгээр Боомтын сэргэлтийн Үндэсний хороонд хандаж Гашуунсухайт боомтын хажууд Гаалийн хяналтын бүс тогтоох зорилгоор 5.5 га талбайг ГЕГ-ын мэдэлд өгөхийг хүссэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Энэ дагуу Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос хяналтын бүс тогтоох газрын координатыг тогтоолгож авсан. Хариу өгөөгүй байна.<br>Мөн 2023 оны 01 сарын 27-ны өдрийн 23/36 тоот албан бичгээр Боомтын сэргэлтийн үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит 2 дугаар хуралдаанаас гарсан 02 дугаар тогтоолын биелэлтийг ирүүлэх тухай бичгийн хариуг 2023 оны 02 сарын 01-ны өдрийн 01/373 албан бичгээр 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 2 дугаар хуралдааны тогтоолын биелэлтийг хүргүүлсэн.<br>Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос 2023 оны 04 сарын 21-ний өдрийн 23/284 тоот албан бичгээр Хятад улсаас боомтын бүтээн байгуулалтад ажиллах ажилчдыг болон тэдний өдөр тутмын хэрэгцээт барааг Гашуунсухайт боомтоор оруулж байх талаар арга хэмжээ авахыг хүссэн Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн нэгжийн саналыг уламжилсан.<br>Энэ асуудлыг БНХАУ-ын Хөх хотноо 2023 оны 4-р сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан Монгол улс, БНХАУ-ын хилийн гаалийн байгууллагын холбоо баригч дарга нарын уулзалтаар хэлэлцүүлж, Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын ерөнхий гүйцэтгэгч “Жунмей инженеринг групп” ХХК-ийн барилгын ажилчдын ахуйн болон хүнсний зориулалтын бараа материалыг зөөх ачааны машиныг Гашуунсухайт-Ганцмод боомт хооронд явуулах талаар талууд харилцан тохиролцсон.<br>Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн 23/727 тоот албан бичгийн дагуу “Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төсөлд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | ГЕГ-аас өгөх саналыг холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 02/3467 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр ирүүлсэн 23/720 тоот албан бичгийн дагуу Замын-Үүд боомтод тулгамдаж буй асуудал, яаралтай шийдвэрлүүлэх шаардлагатай ажлын саналыг ГЕГ-ын холбогдох нэгжүүдээс авч нэгтгэн 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 01/3613 тоот албан бичгээр саналыг хүргүүлсэн.<br>Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 23/675 тоот албан бичиг ирүүлж, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ээлжит хуралдааныг зохион байгуулахаар төлөвлөж байгаа тул хуралдаанаар хэлэлцэх асуудлын санал, өмнөх хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг ирүүлэхийг хүссэн.<br>Албан тоотын дагуу хуралдаанаар хэлэлцэх асуудалд оруулах санал, өмнөх хуралдаанаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 09 сарын 20-ны өдрийн 02/3274 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын тавдугаар хуралдаанд хэлэлцүүлэх асуудлын саналаа Боомтын сэргэлтийн Үндэсний хороонд өгч, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо 2023 оны 08 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд болсон хуралдаанд БХХ-ийн дарга Д.Зоригоо оролцсон. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Боомтын шинэчлэлийн хүрээнд:<br>1.Замын-Үүд боомтын Зорчигч тээврийн хэсгийн барилга байгууламжуудыг Улсын комисст хүлээлгэн өгч, дотоод тохижилт, тэмдэг тэмдэглэгээ, тоноглол, хяналт шалгалтын тоног төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулан байнгын ашиглалтад оруулсан.<br>Ачаа тээврийн хэсгийн барилга угсралтын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. 2023 оны 10-р сарын 02-03-ны өдөр Улсын комисс ажиллаж зарим барилга байгууламжуудыг байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>2.Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлэх, бэлтгэл ажлыг хангах, тулгамдаж буй асуудлыг “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийн нэгжтэй хамтран шийдвэрлэсэн. Гашуунсухайт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 44%-тай байна.<br>3.АХБ-ны RIBS төслийн нэгжтэй Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлын явц, тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэсэн.<br>Алтанбулаг хилийн боомтын авто зам, зогсоолын ажлыг 2023 оны 9-р сарын 12-ны өдөр Улсын комисс шалгаж, байнгын ашиглалтад хүлээн авсан.<br>Мөн нэг дүгээр ээлжийн буюу боомтын доторх зам талбайн ажлыг 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр Улсын комисс үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан. Боомтын доторх автозамын ажлын гүйцэтгэл 94.3<br>4.АХБ-ны RIBS төслийн нэгжтэй Бичигт боомтын бүтээн байгуулалтыг эхлүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх талаар хамтран ажилласан. Бичигт боомтын |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | авто зам, гадна инженерийн шугам сүлжээний ажил 5-р сарын 22-ны өдөр эхэлсэн. Дээрх ажлын гүйцэтгэл 25%-тай байна.<br>5.Боршоо боомтын барилга байгууламжуудыг ашиглалтад оруулах Улсын комисс ажиллуулахтай холбогдуулан ажлын гүйцэтгэл, өмнө хүлээн авсан барилгын дутуу хийгдсэн ажил, эвдрэл гэмтэл болон бүрэн хийгдэж дуусаагүй байгаа ажлын талаар RIBS төслийн нэгж болон гүйцэтгэгч “И Си Си” ХХК, “Сайн констракшн” ХХК, Увс аймаг дахь гаалийн газартай 3 удаагийн уулзалтыг зохион байгуулсан.<br>Боршоо боомтын барилга байгууламжийн барилгын ажил 100%, авто зам, гадна инженерийн шугам сүлжээний ажил 100%-д хүрсэн. Улсын комисс 2023 оны 09-р сарын 06-ны өдөр үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан. |
| 1 | Хилийн боомтын захиргаа байгуулах тухай | 2022.04.06 | | 1. Ашигт малтмал, газрын тос, бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, улс хоорондын тээврийн зохицуулалт, халдвар хамгаалал, хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлын | Хилийн боомтын захиргаа 2021 онд байгуулагдсан бөгөөд хууль тогтоомжид заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Боомтын хөгжлийн хэлтэс Хилийн боомтын захиргаатай хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллээр хангаж байна.<br>Хилийн боомтын захиргаанаас гаргасан хүсэлтийн дагуу 2023 оны 5 дугаар сард 19 боомтын Хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг цахимаар өгсөн.<br>Хилийн боомтын захиргааны дарга Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Сүмбэр, Хавирга, Цагааннуур, Даян, Боршоо, Булган боомтуудаар явж ажилтай танилцахтай холбогдуулан дээрх боомтуудын тухай мэдээллийг шинэчлэн гаргаж хүргүүлсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | уялдаа холбоог нэгдсэн зохицуулалтаар хангах, боомтын хөгжлийн асуудлыг төлөвлөх, орон сууц, цахилгаан, дулаан, цэвэр, бохир ус болон бусад дэд бүтцийг хариуцаж боомтын хэвийн үйл ажиллагааг хангаж хэрэгжүүлэх, хилийн боомт дахь төрийн өмч хөрөнгийг бүртгэж хяналт тавих чиг үүрэг бүхий Хилийн боомтын захиргааг боомтын сэргэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд байгуулсугай. | Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 02 сарын 28-ны өдрийн 23/32 тоот албан бичгээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотын Ардын засгийн газартай хилийн бүсэд хэрэгжихээр бүтээн байгуулалт хийгдэж буй AGV төсөл болон Ганцмод, Гашуунсухайт боомтуудын өмнө тулгарч буй асуудлуудын талаар цахим уулзалтыг хийх тул хэлэлцэх асуудлын саналаа ирүүлэхийг хүссэн.<br><br>Энэ дагуу ГЕГ-ын ХБГ, МТТ болон Гашуунсухайт дахь гаалийн газраас саналыг авч нэгтгэн Хилийн боомтын захиргаанд хүргүүлсэн.<br><br>Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 03 сарын 10-ны 23/41 тоот албан бичиг ирүүлж ажлын хэсэг байгуулах тул ажлын хэсэгт орох албан тушаалтны нэрийг ирүүлэхийг хүссэн.<br><br>Албан бичгийн хариуг 2023 оны 03 сарын 22-ны өдөр ГЕГ-ын 01-3.1/942 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 03 сарын 14-ний өдрийн 23/45 тоот албан бичгээр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хилийн боомтын албатай цахим уулзалт хийхээр төлөвлөж байгаа тул хурлаар хэлэлцэх асуудлын саналаа ирүүлэхийг хүссэн.<br><br>Энэ дагуу гаалийн газар хороод, ГЕГ-ын бүтцийн нэгжүүдийн санал авч нэгтгэн Хилийн боомтын захиргаанд ГЕГ-ын 2023 оны 03 сарын 28-ны өдрийн 01-3.1/1026 тоот албан бичгээр цахим хурлаар хэлэлцүүлэх асуудлын саналыг хүргүүлсэн.<br><br>Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 03 сарын 28-ны өдрийн 23/57 тоот албан бичгээр Монгол, Хятадын хилийн боомтуудыг цайны цаггүй болгох, ажиллах цагийг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | уртасгах талаар БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар, ӨМӨЗО-ны Гаалийн газраас саналыг авна уу гэсэн хүсэлт ирүүлсэн.<br>Дээрх албан бичгийн дагуу ГЕГ-ын 2023 оны 04 сарын 03-ны өдрийн 01-3.1/1090 тоот албан бичгээр Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захиралд хандан энэ талаар Хятад улсын талтай дипломат шугамаар харилцан тохиролцохыг хүссэн хүсэлт явуулсан.<br>Хилийн боомтын захиргаанаас 2023 оны 10 сарын 13-ны өдөр Замын-Үүд боомтын химийн хорт бодисын хадгалалт хамгаалалт хангалтгүй байгаа талаар 23/235 тоот албан бичиг ирүүлсэн.<br>Албан тоотын дагуу 2023 оны 11 сарын 01-ний өдөр 01-3.1/3909 тоот албан бичгийг Замын-Үүд дэх гаалийн газарт илгээж, арга хэмжээ авах шаардлага хүргүүлсэн. |

***ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭРХ ДАРААХ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА. ҮҮНД:***

| № | Эрх зүйн актын нэр | Батлагдсан огноо | Хуулийн холбогдох заалт | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|---|
| 1. | Төрийн албаны тухай хууль | 2017.12.07 | <<...г доор дурдсанаар ангилна: 6.1.1.төрийн улс төрийн алба; 6.1.2.төрийн захиргааны алба; 6.1.3.**төрийн тусгай** алба; 6.1.4.төрийн үйлчилгээний алба. 6.2.Энэ хуулийн 6.1.2, 6.1.3-т заасан албыг төрийн жинхэнэ ал...>> <<...АЛБА | -Сангийн сайдын 2023 оны 29 дүгээр тушаалыг үндэслэн гаалийн байгууллагад нийт 2326 (1805 ТТ, 521 ТҮ) албан хаагч ажиллахаас 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 1870 албан хаагч (1411 ТТ, 459 ТҮ) ажиллаж байна.<br>2023 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 67 албан хаагч Удирдлагын академийн дунд болон богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байна. Үүнд:<br>- Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад -13, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт 1.1.Энэ хуулийн зорилт нь **төрийн албаны мэргэшсэн**, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн...>> <<..., ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн **албан хаагчийн** эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 2 дугаа...>> | - Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад - 42,<br><br>- Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад - 6,<br><br>- Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад - 6.<br><br>-“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” ЗГ-ын 2022.12.28-ны өдрийн 488 дугаар тогтоолоор гаалийн байгууллагын нийт төрийн тусгай албан хаагчийн цалингийн шатлалыг ахиулж, үндсэн цалинг 130-410 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн бол ЗГ-ын 2023.06.21-ний өдрийн ЗГ-ын 241 тогтоолоор үндсэн цалинг 271-368 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.<br><br>-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2004 оны 77 дугаар тушаалын дагуу лабораторид ажиллагсдын ажлын орчныг “хөдөлмөрийн хортой, халуун, хүнд” нөхцөлд тооцуулж, нийт 54 албан хаагчдад нэмэгдлийг олголоо. |
| 2. | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай | 2021.12.17 | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4, 10-р зүйл | Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/ хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдан гарсан бөгөөд гаалийн байгууллагаас энэ хуулийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.<br><br>Гаалийн байгууллагаас дээрх хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:<br><br>1.Тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг болон “Журам батлах тухай” Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/226 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 9.3.2-ийг тус тус үндэслэн Гаалийн ерөнхий газрын нийт ажилтан, албан хаагчид өөрийн биометрийн мэдээллийг /нүүр царай таних төхөөрөмж/-өөр уншуулж, цагийн бүртгэлд хамрагдахыг зөвшөөрсөн болохоо гарын |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | үсгээр баталгаажуулсны дагуу цагийн бүртгэлд хамрагдаж байна. 2023 оны байдлаар нийт 258 албан хаагч нүүр царай таних төхөөрөмжөөр уншуулж, цагийн бүртгэлд хамрагдаж байна.<br>Шинээр шилжиж ирсэн албан хаагч нарт энэ хуулийн холбогдох зүйл заалтыг танилцуулан цаг бүртгэлийн царай таних системд бүртгэн гарын үсэг зуруулан ажиллаж байна.<br>2.“Хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль хэрэгжүүлэх тухай” Тагнуулын ерөнхий газрын 2022 оны 551, Сангийн яамны 2022 оны 12/2847 албан бичгүүдээр ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу “Биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг зааврын дагуу устгаж, тайлан, мэдээг загварын дагуу ирүүлэхийг мэдэгдсэн Гаалийн ерөнхий газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01-1/1227 албан бичгийг харьяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн.<br>Дээрх албан бичгийн дагуу 18 харьяа гаалийн газар, хороодоос ирүүлсэн тайлан, мэдээг нэгтгэн, ГЕГ-ын 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01-1/1258 албан бичгээр Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн. |

***МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР ДАРААХ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА. ҮҮНД:***

| № | Эрх зүйн актын нэр | Батлагдсан огноо | Хуулийн холбогдох заалт | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|---|
| 1. | Кибер аюулгүй байдлын тухай | 2021.12.17 | 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3 дахь | “Гаалийн байгууллагын цахим мэдээллийн аюулгүй байдлын журам”-ыг гаалийн байгууллагын нийт байцаагч нарт cerp.ecustoms.mn байрлуулан танилцуулсан.<br>- Мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг мэдээллээ тогтмол чадавхжуулж мэдээллийн аюулгүй байдлын болон үүлэн технологийн, их өгөгдөлд дүн шинжилгээ хийх, удирдлагын академийн дизайн сэтгэлгээний сургалтад М.Оргил хамрагдсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | заалтыг бүхэлд | - Саммит Комьютер Технологи компани болон АНУ-ын Fortinet компанийн мэргэжилтнүүдийн хамтарсан харилцаа холбоо, кибер аюулгүй байдлын шийдлийг танилцуулах “Кибер аюулгүй байдлын хүчирхэг хамгаалалтыг үүсгэх нь” арга хэмжээнд ГУБ Ж.Амарбаяр 2023 оны 11 сарын 2-ны өдөр оролцсон.<br>- Гаалийн байгууллагад ашиглагдаж байгаа системд эрсдэлийн үнэлгээ хийлгэх хүсэлтийг Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүргүүлсэн.<br>- Тус хүсэлийг дагуу аудит хийх хуваарьд 2024 онд хийлгэхээр төлөвлөгөөнд нь тусгуулан ажиллаж байна. |
| 2. | Цахим гарын үсгийн тухай хууль | 2021.12.17 | | - Системийн хэмжээнд удирдлагууд болон хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгох ажлын хүрээнд 2023 оны 11 сарын 16-ны өдрийн 11:00 цагт “Тридиум Э-секюрити” ХХК-аас холбогдох албан хаагч ирж ГЕГ-ын дарга нар болон бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн ГУАБ, ГУБ нарын тоон гарын үсгийн төхөөрөмжийг холбохоор болсон.<br>- Тус ажлын хүрээнд тоон гарын үсгийн төхөөрөмж авахад шаардлагатай дагалдах бичиг баримтууд буюу байгууллагын итгэмжлэл, байгууллагын гэрчилгээ ний хуулбар, холбогдох албан хаагчдын анкет, гэрээ, иргэний үнэмлэхний хуулбар болон тоон гарын үсгийн төхөөрөмжийн бэлдэж тоон гарын үсгийг суулгуулж 69 тоон гарын үсэг бэлэн болж хүлээн авсан ба хэрэглээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна.<br>- Тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүдэд ашигладаг болно. (I-IV улирал) |

***САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛААГААНЫ ЧИГЛЭЭР ДАРААХ ХУУЛЬ ТОГТООМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАВ. ҮҮНД:***

| № | Эрх зүйн актын нэр | Батлагдсан огноо | Хуулийн холбогдох заалт | Хэрэгжилтийн байдал |
|---|---|---|---|---|
| 1. | Төсвийн тухай хууль | 2011.12.23 | | СХОГазар нь чиг үүргийнхээ хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж гаалийн байгууллагын урсгал төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилаж, төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулж, гүйцэтгэлийг тайлагнан ажилладаг. |
| | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль | 2005.12.01 | | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Гаалийн байгууллага 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөндөө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 3 арга хэмжээ, нээлттэй тендер шалгаруулалтаар 3 арга хэмжээ, ерөнхий гэрээгээр 8 арга хэмжээ, урсгал зардлаас нээлттэй тендер шалгаруулалтаар 12 арга хэмжээ, харьцуулалтын аргаар 26 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласан. /Дэлгэрэнгүй тайланг Сангийн яам болон Гаалийн ерөнхий газрын захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн./<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхлэхтэй холбогдуулан Сангийн яамнаас худалдан авах ажиллагааны А-3 серификаттай болон сертификатгүй гаалийн байгууллагын албан хаагчдад 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 09 цагаас 17 цаг 30 минутад сургалт зохион байгууллаа.<br>Сургалт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулга, хуулийн үйлчлэх хүрээ, тендер зохион байгуулах, тайлагнах, захиалагч, үнэлгээний хорооны чиг үүрэг, шийдвэр |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | гаргахад анхаарах хүчин зүйл, гэрээний үүргийн гүйцэтгэл, тендер шалгаруулалтын гомдол, маргаан зэрэг сэдрийн талаар явагдлаа.<br>Сургалтад гаалийн байгууллагын 70 албан хаагч хамрагдлаа. Үүнээс танхимаар 46 албан хаагч, цахимаар газар, хороодын 24 албан хаагч хамрагдсан.<br>Сургалтад хамрагдсан 70 албан хаагчийн 32 нь худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А-3 сертификаттай байна.<br>Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны А-3 сертификатгүй албан хаагчид Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулах шалгалтад хамрагдаж А-3 сертификаттай болох юм. |
| | Төрийн хэмнэлтийн хууль | 2022.04.29 | | Гаалийн байгууллага Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр Гаалийн ерөнхий газрын даргын албан даалгавар боловсруулж батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:<br>Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын дарга нарт тодорхой үүрэг даалгавар, чиглэл өгч байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, харьяа газар, хороодод хуваарилсан төсвийг дахин хуваарилах, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах зэрэг зохицуулалтыг хийн ажиллаж байна. |

**Хүрсэн үр дүн:**

Хууль тогтоомжийн 2023 оны жилийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох эрх зүйн акт болон төрийн удирдах дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг гаалийн байгууллага биелүүлж ажилласан байна.

Гаалийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагаатай холбоотой, давхардсан тоогоор нийт 62 хуулийн жагсаалтыг үүсгэсэн бөгөөд Гаалийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд хамаарах хуулиудын хэрэгжилтийн биелэлтийг гаргуулан авч, хууль тогтоомжийн хэрэгжилтийн 2023 оны хагас жилийн тайланг Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд /утас: 267246/ bayanmunkh_z@mof.gov.mn цахим хаягаар 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн тайланг үүгээр гаргасан бөгөөд одоогийн байдлаар Сангийн яамнаас тайлан хүлээн авах хугацааг хүлээж байгаа болно.

***1.2.УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийнбиелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ.***

**Хүрэх үр дүн:**

УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ.

**Шалгуур үзүүлэлт:**

Хэрэгжилт, гүйцэтгэлээр

**Биелэлт:**

Сангийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “ГЕГ-ын зохион байгуулалтын бүтцийг батлах, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай” 29 дугаар тушаалаар Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтад өөрчлөлт орж Хуулийн хэлтсийн чиг үүрэгт “УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэх” арга хэмжээ 2023 оны 03 дугаар сараас нэмэгдсэн.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон тус журмын нэгдүгээр хавсралт “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт болон байгууллагын үйл ажиллагааг тайлагнах хугацаа”-г тус тус үндэслэн тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэн ажилласан байна. Тус ажлын хүрээнд ГЕГ-т хамаарах

- УИХ-ын тогтоол - 4
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж - 1
- Засгийн газрын тогтоол - 16
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл - 10
- Засгийн газрын албан даалгавар - 2 буюу нийт 33 тогтоол шийдвэрийн биелэлтийг холбогдох нэгжүүдээс заасан хугацаанд гаргуулан авч Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд цахимаар буюу bayanmunkh_z@mof.gov.mn хаяг руу тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

**Хүрсэн үр дүн:**

УИХ-ын тогтоол -4, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж -1, Засгийн газрын тогтоол -16, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -8, Засгийн газрын албан даалгавар -2, нийт 31 тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг

- 2023.04.05-нд 3-р сарын хэрэгжилт;
- 2023.05.01-нд 4-р сарын хэрэгжилт;
- 2023.06.02-нд 5-р сарын хэрэгжилт;
- 2023.06.27-нд 2023 оны хагас жилийн хэрэгжилт;
- 2023.08.03-нд 7 дугаар сарын хэрэгжилт;
- 2023.09.04-нд 8 дугаар сарын хэрэгжилт;
- 2023.10.04-нд 9 дүгээр сарын хэрэгжилт;
- 2023.11.03-ны өдөр 10 дугаар сарын хэрэгжилтийг тус тус гарган Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд цахимаар /99010806/ цахимаар буюу bayanmunkh_z@mof.gov.mn хаяг руу тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Жагсаалтыг хавсралтаар оруулав.

## *1.3.ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ*

**Хүрэх үр дүн:**

1. Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар тайлагнана.

**Шалгуур үзүүлэлт:**

Хэрэгжилт, гүйцэтгэлээр

**Биелэлт:**

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, ЗГ-ын 2022 оны “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 362-р тогтоол, МУ-ын Ерөнхий сайдын 2022 оны “Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай” 10-р албан даалгавар, Сангийн сайдын 2019 оны “Жагсаалтад нэмэлт оруулах тухай” 142-р тушаалыг тус тус үндэслэн тодорхой нэр төрлийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргах, суурилуулах байршлыг тогтоох, нийлүүлэгчийн сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсэг орж ажилласан.

2.ГЕГ-ын харьяа гаалийн газар, хороодын дарга нарын 2023.01.01-2023.11.30-ний өдрийн хугацаанд баталсан 1220 тушаалыг хянаж Төрийн албан тухай хууль, Гаалийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай зэрэг хуульд нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгасан.

ГЕГ-ын даргын 2019 оны А/142 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар, хорооны дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалтыг үндэслэн харьяа гаалийн газар, хороодын дарга нар эрх хэмжээнийхээ хүрээнд захиргааны акт боловсруулан гаргах явцад алдаа, дутагдал гарсаар байгаа.

Иймд Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн харьяа гаалийн газар, хороодын дарга нарын түгээмэл батлан гаргадаг 19 тушаалын үлгэрчилсэн загварыг Хуулийн хэлтсээс боловсруулан 2022 оны 12 дугаар сард хүргүүлсэн байсан.

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан 2023 онд дараах 2 тушаалын үлгэрчилсэн загварыг шинээр, үндэслэл болгосон зарим хууль тогтоомж хүчингүй болгосонтой холбогдуулан 4 тушаалын төслийг шинэчлэн Гаалийн захиргаа, дотоод ажлын системд байршуулах замаар харьяа гаалийн газар, хороодод түгээсэн. Үүнд:

1."Төрийн үйлчилгээний албан хаагч нарын сарын үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай";

2.Хөрөнгө бүртгэлд тусгах тухай";
3."Ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай";
4."*Улирлын ажилтныг* Ажилд томилох тухай";
5."*Төрийн үйлчилгээний албан хаагчийг* ажилд томилох тухай";
6."Б.Батад сахилгын шийтгэл ногдуулах тухай".

**3.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 дугаар тушаалаар "Хяналт шалгалтын рентген тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/15 дугаар тушаалаар "Гаалийн хяналт, шалгалтад ашиглагдах нэг удаагийн ломбо нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/29 дугаар тушаалаар "Гаалийн ерөнхий газрын шуурхай удирдлагын төв болон гаалийн төв лабораторийн харуул хамгаалалтын үйлчилгээг гүйцэтгэх" тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/01 дугаар тушаалаар "Гаалийн байгууллагын албан хаагчдын дүрэмт хувцас нийлүүлэгчийг сонгон шалгаруулах" тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажиллаж байна.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/224 дугаар тушаалаар “Гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерт үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/228 дугаар тушаалаар “Гашуунсухайт хийлийн боомтын тохижилт, тоног төхөөрөмж /Өмнөговь, Ханбогд сум/ нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах” тендерийн үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

- Гаалийн ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/... дугаар тушаалаар “Өмнөговь аймгийн "Оюутолгой" ХХК дахь Гаалийн хяналтын бүсэд баригдсан Гаалийн салбар лабораторийн барилгын агаар сэлгэлт, цахилгаан хангамжийн өөрчлөлтийн угсралтын ажлыг гүйцэтгэх нээлттэй тендерийн үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг үндэслэн мөн хуулийн 21 дүгээр зүйлд заасан хариуцагчийн эрх, үүрэг болон 28 дугаар зүйлийн 28.2.1-т “нэхэмжлэлд гарын үсэг зурах, хариу тайлбар гаргах”, 28.2.6-т “шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах” гэж заасан эрхийг хэрэгжүүлэх хүрээнд 2023 онд нийт 5 захиргааны хэрэгт гаалийн байгууллагыг төлөөлөн ажилласан.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг үндэслэн мөн хуулийн 25 дугаар зүйл, 26.3 дахь хэсэг/эвлэрэхээс бусад/-т заасан эрхийг хэрэгжүүлэх эрхийн хүрээнд 2023 онд нийт 2 иргэний хэрэгт гаалийн байгууллагыг төлөөлөн ажилласан.

5.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйл./Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хариу өгөх хугацаа/-ийн 1дэх хэсэгт “Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ.” гэж заасны үндэслэн Хуулийн хэлтэс ирүүлсэн 313 албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

**Хүрсэн үр дүн:**

Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль зэрэг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 887 хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах захиргаа болон иргэний 7 хэрэгт гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн 92 гэрээний төсөл, 13 журам, дүрмийн төсөл болон тайлант хугацаанд хуулийн хэлтэст ирсэн 373 бичиг, явсан 313 бичиг, 21 өргөдөл гомдол зэрэг нийт 707 албан бичгийн төслийг хянаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

**Дүгнэлт:**

**Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд дээрх 3 арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд нэгтгэн дүгнэхэд** холбогдох эрх зүйн акт болон төрийн удирдах дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг гаалийн байгууллага биелүүлж ажилласан байна.

Гаалийн байгууллагын чиг үүрэг, эрхлэх үйл ажиллагаатай холбоотой, давхардсан тоогоор нийт 62 хуулийн жагсаалтыг үүсгэсэн бөгөөд Гаалийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдээс гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд хамаарах хуулиудын хэрэгжилтийн биелэлтийг гаргуулан авч, хууль

тогтоомжийн хэрэгжилтийн 2023 оны хагас жилийн тайланг Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн З.Баянмөнхөд /утас: 267246/ bayanmunkh_z@mof.gov.mn цахим хаягаар 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Мөн УИХ-ын тогтоол- 4, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж -1, Засгийн газрын тогтоол-16, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-8, Засгийн газрын албан даалгавар-2, нийт 31 тогтоол шийдвэрийн биелэлтийг ЗББН-ээс гаргуулан авч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн нэгтгэсэн тайланг сангийн яаманд хүргүүлсэн.

Мөн Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гаалийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль зэрэг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 887 хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах захиргаа болон иргэний 7 хэрэгт гаалийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, холбогдох нэгжүүдээс ирүүлсэн 92 гэрээний төсөл, 13 журам, дүрмийн төсөл болон тайлант хугацаанд хуулийн хэлтэст ирсэн 373 бичиг, явсан 313 бичиг, 21 өргөдөл гомдол зэрэг нийт 707 албан бичгийн төслийг хянаж хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

---oOo---